

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай”
Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай

Улс орны нийгэм, эдийн засаг, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж ирсэн бөгөөд 2022 онд 1,9 сая тонн, 2023 онд 2.4 сая тонн, 2024 онд 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортлон хэрэглэж байсан бол 2025 онд импортын хэмжээ 2.9 сая тонн болж өмнөх оноос 0.1 сая тонноор өссөн. Цаашид 2026 онд 3.0 сая тн, 2027 онд 3.1 сая тн-д хүрэх төлөвтэй байна.

Өнөөдрийн байдлаар манай улс шатахууны хэрэглээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд нийт импортын 95 орчим хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлж байна.

Хүснэгт 1: Шатахууны онцгой албан татварын хэмжээ


РОСНЕФТЬ КОМПАНИАС 2026 ОНЫ 03-Р САРД НИЙЛҮҮЛЭХ ШАТАХУУНЫ ХИЛ ҮНЭЭС ТООЦСОН ӨРТГИЙН ТООЦОО (СРТ-Наушки, Төвийн бүс)							
		Ам.долларын ханш				3565.95	2026.03.05
Шатахууны төрөл	Хэмжих нэгж	Аи-92	Аи-92 /К-5/	Аи-95	Аи-98	ДТ	ДТ /К-5/
Шатахууны хувийн жин	кг/л	0.760	0.760	0.738	0.736	0.840	0.840
Импортын үнэ (хил үнэ)	\$/тн	705	765	735	785	737	927
	₮/тн	2,513,995	2,727,952	2,620,973	2,799,271	2,628,105	3,305,636
Гаалийн албан татвар 5%	₮/тн	125,700	136,398	131,049	139,964	131,405	165,282
Онцгой албан татвар	₮/тн	0	0	210,000	210,000	0	0
Автобензин, дизель түлшний албан татвар	₮/тн	25,700	25,700	25,700	25,700	2,140	2,140
Төмөр замын тээврийн зардал	₮/тн	16,400	16,400	16,400	16,400	16,400	16,400
Авто тээврийн зардал	₮/тн	4,200	4,200	4,200	4,200	4,200	4,200
Үйл ажиллагааны дотоод зардал	₮/тн	450,000	450,000	450,000	450,000	450,000	450,000
НӨАТ 10%	₮/тн	313,599	336,065	345,832	364,553	323,225	394,366
Зээлийн хүүгийн дүн	₮/тн	35,933	38,507	39,627	41,772	37,036	45,188
Өртөг	₮/тн	3,485,527	3,735,222	3,843,781	4,051,859	3,592,512	4,383,211
	₮/л	2,649	2,839	2,837	2,982	3,018	3,682
УБ жижиглэн үнэ		2,590	3,070	3,610		3,140	3990
Өртөг болон жижиглэнгийн үнийн зөрүү		(59)	231	773		122	308

Улсын хэмжээнд 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Аи-92 автобензин 38 хоног, Аи-95 автобензин 74 хоног, дизель түлш 25 хоног, ТС-1

онгоцны түлш 23 хоног, шатдаг хийн 34 хоногийн ердийн хэрэглээний үлдэгдэл, нөөцтэй байна.

Зураг 1. Жижиглэн үнэ


АИ-92 АВТОБЕНЗИН БОЛОН ДТ-НИЙ ЖИЖИГЛЭН БОРЛУУЛАЛТЫН ҮНИЙН МЭДЭЭЛЭЛ



ОХУ-ын Роснефть компаниас 2026 оны 02 дугаар сард 84,140 тонн Аи-92 автобензин, 2,400 тонн Аи-95 автобензин, 97,880 тонн дизель түлш, Газпромнефть компаниас 15,000 тонн Аи-92 автобензин, 10,000 тонн дизель түлш, Нефтьхимисервис компаниас 15,000 тонн Аи-92 автобензин, 35,000 тонн дизель түлш, Хетон ойл компаниас 13,640 тонн Аи-92 автобензин, Балчук /Regar/ компаниас 5,000 тонн дизель түлш, бусад компаниас 840 тонн Аи-92 автобензин, 13,570 тонн дизель түлш буюу нийт 292,470 тонн шатахуун худалдан авахаар захиалсан байна.

Зураг 2. Хил үнэ

АИ-92 автобензин, дизель түлшний хил үнийн өөрчлөлт 2024-2026.02



Эх сурвалж: АМГТГ

Дээрх нөхцөл байдлаас Аи-92 шатахууны /НӨАТ, Гаалийн албан татвар, автобензин, дизель түлшний албан татвар/-ууд, импортын үнэ, үйл ажиллагааны

зардлыг тооцсон 3 дугаар сарын жижиглэн борлуулалтын үнийн өртгийг тооцоолоход литр тутамд 2,648 төгрөг хүрч өнөөдөр борлуулж байгаа 2,590 төгрөгнөөс өртөг нь даваад байна.

Одоо борлуулж байгаа Аи-92 шатахууны гаалийн албан татвар тонн тутамд 125,633 төгрөг бөгөөд гаалийн албан татварыг 0 төгрөг болгосноор литр тутамд үнэ 106 төгрөгөөр багасаж 57 төгрөгийн ашигтай болохоор байна.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар нийтийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох автобензиний гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох эрхийг Засгийн газарт олгох, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гаалийн албан татварыг тогтоох, зохицуулалт хийх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сард соёрхон баталсан. Бусад гишүүн орнууд хэлэлцээрийг баталснаар автобензиний гаалийн татвар “0”-лэгдэх болно.

Иймд “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26,” гэсний дараа “27,” гэж нэмэхээр тусгасан бөгөөд 2 дугаар зүйлд Улсын Их Хурлын тогтоолын үйлчилж эхлэх болон хүчин төгөлдөр байх хугацааг тус тус тусгасан.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай тус тус нийцсэн болно.

--ooOoo--